

“Баянтээг” ХК-ийн 2015 оны үйл ажиллагааны тайлан

1.1 Уулын ажлын тайлан:

Баянтээгийн уурхай 2015 онд 260.0 мян.м³ хөрс хуулж 95.0 мян.тн нүүрс олборлон борлуулах төлөвлөгөөтэй ажилласан. Хөрс хуулалтанд ЭКГ-5А экскаватор-1ш, HUYNDAI-520-LC-9S экскаватор-1ш, TEREX 3305E авто самосвал-2ш, NORD BENZ авто самосвал-2ш, HOWO-60 автосамосвал-2ш, D65E бульдозер-1ш, SD-300 автоашигч-1ш зэрэг техник 2 ээлжээр ажиллаж, Хөрс хуулалтыг 45-50, 52-53-р хайгуулын шугам хооронд нийт 319,8 мян.м³ хөрс хуулж, Нүүрс олборлолтыг 45-52-р хайгуулын шугам хооронд нийт 111.546 мян.тн нүүрс олборлон борлуулж хөрсний төлөвлөгөөг 123%, нүүрсний төлөвлөгөөг 117.37%-тай төлөвлөгөөг давуулан биелүүлсэн. Шилжих нүүрсний нөөц 40.0 мян.тн байна.

Хөрс хуулалт, нүүрс олборлолт, борлуулалтын төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт¹

1	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Төлөвлөгөө	Биелэлт	Гүйцэтгэлийн хувь
1	Нүүрс гаргалт	мян.тн	95.0	111.5	117.37%
2	Хөрс хуулалт	мян.м ³	260.0	319.9	123.0%
3	Нүүрс борлуулалт	мян.төг	1900000.0	2230934.0	117%


Нүүрс татан авалт аймгуудаар:

Хүснэгт²

1	Аймаг	2015 оны төлөвлөгөө /мян.тн/	2015 оны гүйцэтгэл /мян.тн/	Борлуулалтанд эзлэх хувь	Сарын дундаж татан авалт /мян.тн/
1	Архангай	12.5	16.6	14,9%	3.3
2	Баянхонгор	18.3	22.5	20,2%	4.2
3	Өвөрхангай	54.7	56.8	50,9%	16.1
4	Булган	1.0	2.0	1.8%	6.8
5	Улаанбаатар	3.7	5.5	5%	12
6	Говь-Алтай	1.0	2.8	2.5%	0.25
7	Дархан	1.0	1.6	1.4%	4.8
8	Завхан	1.0	1.3	1.2%	0.15
9	Төв	1.0	1.55	1.4%	0.32
10	Сэлэнгэ	0.2	0.24	0.2%	0.15
11	Хөвсгөл	0.1	0.11	0.1%	0.01
12	Эрдэнэт	0.5	0.5	0.4%	0.05
	Дүн	95.0	111.5		


"Баянтээг" ХК-ийн 1963-2016он хүртлэх олборлосон нүүрс, хуулсан хөрсийг графикаар үзүүлэв

Нүүрс	мян.тн
1963-1967	78.3
1968-1972	241.9
1973-1977	544.2
1978-1982	1007.7
1983-1987	1032.9
1988-1992	1039.7
1993-1997	394.3
1998-2001	186.7
2001-2002	37319
2003-2004	35003
2004-2005	32546
2005-2006	30072
2006-2007	26038.4
2007-2008	36512
2008-2009	36255.1
2009-2010	36570.2
2010-2011	47032.92
2011-2012	55379.66
2012-2013	68912.41
2013-2014	91461.6
2014-2015	104817.4
2015-2016	111546.7
Нийт дүн	753992.09



1963-2015 Хөрс хуулалт

Хөрс	мян.мЗ
1963-1967	198
1968-1972	297.7
1973-1977	366.9
1978-1982	861.3
1983-1987	1116.8
1988-1992	1499.7
1993-1997	649.5
1998-2002	362.9
2003-2007	277.3
2008-2012	475.0
2013-2014	226.9
2014-2015	251.93
2015-2016	319.8
Нийт дүн	6903.735



1.2 Санхүүгийн ажлын талаар:

2015 онд 2582.8 сая.төгрөгийн орлого олж 7.8 сая.төгрөгийн хөнгөлөлт үзүүлж, сая.төгрөгийн 2575.0 сая.төгрөгийн цэвэр орлоготой ажилласан. 2170.2 сая төгрөгийн зардал гарган 404.8 сая.төгрөгийн ашигтай ажилласан. 2015 онд Өвөрхангай, Баянхонгор, Архангай, Булган Дархан, Улаанбаатар, Говь-Алтай, Хөвсгөл, Төв, Эрдэнэт, Завхан, Төв аймгийн байгууллага, иргэдэд нийт 111546.70 мян.тн нүүрс борлуулж, 42 байгууллагатай гэрээ байгуулан нүүрс борлуулсан байна.

2012 онд Улсын төсөвт 298.9 сая.төгрөг,

Орон нутагт 55.3 сая.төгрөгийн татвар төлсөн.

2013 онд Улсын төсөвт 352.9 сая төгрөг,

Орон нутагт 63.6 сая.төгрөгийн татвар төлсөн.

2014 онд Улсын төсөвт 220.3 сая төгрөг,

Орон нутагт 15.2 сая төгрөгийн татвар төлсөн.

2015 онд Улсын төсөвт 316.2 сая төгрөг

Орон нутагт 17.4 сая төгрөгийн татвар төлсөн.

1.3 2015 хийгдсэн хөрөнгө оруулалтын тайлан

Хүснэгт⁴

д/д	Нэр	Тоо ширхэг	Төлөвлөсөн зардал /мян.төг/	Гүйцэтгэлээр зардал /мян.төг/
1	Тэсэлгээний өрмийн машин	1	705000.0	690000.0
2	Маркшейдерийн багаж	1	70000.0	2016 онд хийгдэнэ
3	Пургон УАЗ-31512	1	31000.0	27000.0
4	50-Ковш	1	145000.0	142000.0
5	55/2800-1315-51 усны носас	ком	8000.0	8750.0
6	Усны шаланг /м/ ф 250 200м	тоо	4000.0	4000.0
7	Карьерийн гал тогооны байр /Вогончик/	1	8500.0	8500.0
8	Контейнор/доторлогоотой/6*2,15/	1	6500.0	8250.0
9	Контейнор/доторлогоотой/6*2,15/	1	6500.0	7207.5
	Дүн		984500.0	895707.5

1.4 Нийгмийн асуудлаар хэрэгжүүлсэн ажил:



“ Баянтээг “ ХК- нь үйлдвэрлэлийн үр ашиг үйл ажиллагааг дээшлүүлэхийн зэрэгцээ орчины тохижилт спорт, соёлжилтыг дээшлүүлэх , уурхайчдын нийгмийн асуудлыг дээшлүүлэн шийдвэрлэх талаар бүтээлтэй үр өгөөжтэй олон арга хэмжээ авч ажилласан.

- Үүнд

- Ажилчдад үнэгүй хоол, аарцаар үйлчилсэн
- Нийт ажилчид, өндөр настан, групптэй хүмүүс, багийн амьжиргааны баталгаажуулах түвшингээс доогуур айл өрхөд, нийт 232.5 тн буюу 5347.5 мян.төгрөгийн нүүрс олгосон.
- Төвлөрсөн дулааны төсвийн байгууллагуудыг хямдралтай үнээр нүүрсээр хангаж байна.
- Салбарын хамтын гэрээний дагуу буцалтгүй тусламж 5132.5 мян.төгрөг олгосон.
- Өндөр настаныг хүлээн авах, тэтгэмж 1281.7 мян.төгрөг
- Ажилчдын дунд зохиогдсон уралдаан тэмцээний шагнал 2577.5 мян.төг тус тус зарцуулсан
- Карьерийн гэрэлтүүлэгийг сайжируулах зорилгоор 15 прожектур байрлуулав.
- Нийт ажилчид 45 хүнд биеийн тамирын иж бүрэн хувцас олголоо 6300.0
- 2015 онд Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа менежерын сургалтанд Б.Энхтуяа /Дотоод хяналт/, М.Намнансүрэн /Ашиглалтын инженер/, А.Батжаргал /Жолооч/ нарыг 1300.0 төг. Уулын тэсрэх материалын харьцах болон тэсэлгээчны эрх сунгах сургалтанд С.Хүрэлбат /Цахилгаанчин/, Ү.Цэдэвдорж /Өрөмдөгч/ нарыг 490.0 төг, Худалдан авах АЗ-ын сургалтанд 5 ажилтан 400.0 төгрөгөөр тус тус сургалтанд хамруулсан
- “Ахмадын өргөө”-г 21340.7 мян.төг материалын зардлыг компаниас гарган, өөрсдийн ажилчдын хүчээр барьж 2015 оны 7 дугаар сард ашиглалтанд оруулж Багийн Ахмадын хороонд хүлээлгэн өгсөн.
- Нарийнтээл сумын Засаг дарга болон Нарийнтээл сумын УБ нутгийн зөвлөлийн хүсэлтээр “Сум сурталчлах өдөрлөг”-г 3000.0 мян.төг тусламж үзүүлсэн
- Хариуцсан ажилдаа идэвхи санаачлагтай ажиллаж байгаа 10 ажилтаныг компанийн зардлаар Итгэлт хамба, Байгаль нуур аялалд 7 хоног Тэнгэр трэйвл ХХК-иар зуучлуулан аялуулсан /5400.0 төгрөг/.
- Хөдөлмөр хамгаалалын зүгээс ажилчдыг маск савангаар хангаж, халуун усны үйлчилгээгээр үнэ төлбөргүй үйлчилж байна.

- МШӨ-ний улмаас групп тогтоолгосон 26 хүнийг БОЭТөвд шинжилгээнд хамруулан Хөдөлмөрийн өвчин судлалын эмч нарыг бүрэн бүрэлдхүүнээр нь авч ирэн группын сунгалт болон Компанийн 40 ажилтанийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулав./үзлэгийн зардал 2000.0/
- Компанийн хашаанд 400 чацаргана, 70 улиас нэмж тарьсан бөгөөд ургалт 70 хувьтай байгаа.
- 1 Дан байрны дээвэрийг шинэчлэн вакуум цонхтой болгов.Мөн даврхын бүх хаалгыг Төмөр хаалгаар шинэчлэв.
- Конторын арын 150 м хайсыг шинэчлэн үзэмж чанарыг дээшлүүлэв.
- Ажилчдын цайны газарт Хөргөгч Цахилгаан зуухыг шинээр авав.
- 45 м явган хүний зам тавилаа.
- Карьер,тэсрэх,уурхайн Кэмп хавьд нийт 15 камер суурилуулж, Тэсрэх материалын агуулахыг гэрэлтүүлэх зориулалтаар Нарны толь, Салхин сэнс суурилуулалж, хашаан дотор 540 м агаарыг шугам татлаа.
- Тэсрэх материалын хашааны хамгаалатыг сайжируулах зорилгоор 500 кг өргөст торыг нэмж татсан.
- Засварын барилгын дээвэрийг 600 м2 төмөрөөр дээвэрлэв.
- Ашиглахгүй байсан Терех 3305-н мотор, короныг солин 2015 оны хөрс тээвэрт ажилуулав.

1.5 Хөдөлмөр хамгаалалтын тайлан.

Уурхайн үйл ажиллагаатай уялдуулан ХАБЭА-н чиглэлээр төлөвлөгөө боловсруулж үүний дагуу ажилтаны сургалтыг зохион байгуулж,ажлын байрны орчин,ажиллах нөхцлийг жилээс жилд сайжруулан “аюулгүй ажиллацгаая” гэсэн зорилтыг өмнөө тавьж ажилчдын ажилын байран дээр ажиллах бүхий л аюулгүй талыг хангах ,ажилчдын нийгэмд эзлэх байр суурыг нэмэгдүүлэх тал дээр ажилын хэсэг байгуулан ажиллаж байна.

Уурхайн ажилчдыг ажилд гарахын өмнө, Компанийн хөдөлмөрийн дотоод журмын 2.1.3 а –д заалтын дагуу ажлын байрандах аюулгүй ажииллагааны зааварчилгааг өгч ,эрүүл аюулгүй ажлын байрыг мөрдлөг болгон ажиллаж байгаа.

Ажилчдад, Компанийн хөдөлмөрийн дотоод журмын 2.1.2 г-дзаасны дагуу улирлын чанартай нормын хувцасны эдэлгээний хугацааг 1 жилээр тооцож стандарт, чанарын шаардлагын дагуу итгэмжлэгдсэн оёдлын “Асралт баян хайрхан” ХХК –тай гэрээг байгуулан ажиллаж байна.

Хангалт болох бээлий бусад нэг бүрийн хамгаалах хэрэгслийн хугацааг богиносгож хэрэглэх нөхцөлт болгосон.

Уурхайн бүст болон өндөр хүчдэлийн трансформатор замын хэсгүүдэд /заах,хориглох,анхааруулах /замын тэмдэг тэмдэглэгээг хийж байршуулсан нийт 52 ш

Үйлчлүүлэгч тээврийн хэрэгслийн жолооч нарт зааварчилгыг нэвтрэх бүрт өгч зөрчил гаргасан жолооч нарт давтан нэмэлт зааварчилгааг өгч ажиллаж байна.

Ажилчдын эрүүл мэндийг дэмжих зоригоор идэвхитэй хөдөлгөөнийг зохион байгуулж спорт заланд тэмцээн уралдаан зохион байгуулж байна.

Хүйтэн сэрүүний улиралд халуун чацаргана, аарцыг өдөр бүр ажилчдадаа 200г-р уулгаж байна.

Гал командыг байруудыг сэргээн засварлав.

ШТМ-н хог хаягдыг байгаль орчинд хор хөнөөлгүй байлгах тал дээр.

Засвар, үйлчилгээний ажлыг зориулалтын талбай гражид гүйцэтгүүлж үүнээс гарсан хог хаягдалыг тусгайлан бэлтгэсэн хогийн саванд хийн хуримтлуулан устгаж байгаа. Техникийн аюулгүй ажиллагааг хангахтай холбоотой үзлэг үйлчилгээг өдөр тутам зааварчилгаагаар олгож хэрэгжилтийг биечлэн болон авто хариуцсан ИТА-р шалгуулан ажиллаж байна.

Ажлын байран дахь эрүүл ахуйн стандарт, дүрэмийг уурхайн үйл ажиллагааны онцлогт тохируулан хэвшүүлж мөрдүүлэх тал дээр удирдлага, ИТА-дтай хамтран ажиллаж байна.

Уурхайн хэмжээнд аваар устгах төлөвлөгөөг жилээс жилд шинэчлэн боловсруулж ажилчдад танилцуулах сургалт, гал түймрийн үед хэрхэн ажиллах, гэнэтийн ослын үед ажиллах арга хэмжээний талаар биечилсэн сургалтыг зохион байгуулав.

Гал унтраах багаж, хэрэгсэлд долоо хоног бүр үзлэг хийж бүрэн бүтэн байдлын шалгаж, ашиглах хугацаа дууссан болон даралт нь унасан галын хорыг сэлгэн шинэчлэж байна.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг жил болгон шинэчлэн боловсруулж, галын аюулаас урьдчилан сэргийлэх, галын аюулын хор хөнөөлийн талаархи мэдээ мэдээлэл, баримт материалыг суртачилан таниулах зорилгоор мэдээллийн самбарыг мэдээллээр хангаж, хууль болон бусад мэдээ мэдээллийг цаг тухайд танилцуулж байна.

ХАБЭА-н талаархи болон бусад үйл ажиллагаатай холбоотой харилцаа үйлчилгээ, ёс зүйн талаархи мэдээ мэдээлэл, санал, гомдлыг шийдвэрлэх зорилгоор санал, хүсэлтийн хайрцгыг байгуулж, байршуулав.

Уурхайн хөрс хуулалтын үед үүссэн тоос шороог багасгах үүднээс усны хадгалах савыг зориулагдсан талбайд хийлгэж байршуулан зам усалгааны ажлыг үр бүтээлтэй явуулав.

Уурхайн үйл ажиллагаатай уялдуулан ХАБЭА-н чиглэлээр төлөвлөгөө боловсруулж үүний дагуу ажилтаны сургалтыг зохион байгуулж, ажлын байрны орчин, ажиллах нөхцлийг жилээс жилд сайжруулан “аюулгүй ажиллацгаая” гэсэн зорилтыг өмнөө тавьж ажилчдын ажилын байран дээр ажиллах бүхий л аюулгүй талыг хангах, ажилчдын нийгэмд эзлэх байр суурыг нэмэгдүүлэх тал дээр ажилын хэсэг байгуулан ажиллаж байна.

Уурхайн ажилчдыг ажилд гарахын өмнө, Компанийн хөдөлмөрийн дотоод журмын 2.1.3 а –д заалтын дагуу ажлын байрандах аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч, эрүүл аюулгүй ажлын байрыг мөрдлөг болгон ажиллаж байгаа.